

**“МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН ТОВЧОО
(2018 оны жилийн эцсийн байдлаар)**

2019 оны 03 дугаар сарын 29

№	Хөтөлбөр/төслийн агуулга	Гүйцэтгэл			
1	<i>Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар:</i> Засгийн газрын 2018 оны “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай 12 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус тус баталсан.	<i>Хөтөлбөрийн зорилго:</i> Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан, эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй, тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эздээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.			
2	Санхүүжилтийн эх үүсвэр	1. Улсын төсөв, олон улсын байгууллага, гадаад орны зээл, тусламж, төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; 2. Гоц халдварт, халдварт, зооноз өвчин дэгдсэн онцгой байдлын үед улсын болон орон нутгийн төсөв; 3. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж; 4. Хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.			
3	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: ХХААХҮЯ, МЭЭГ Хугацаа: 2018–2021 он Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Мал эмнэлгийн салбарын байгууллага, Орон нутгийн Засаг дарга			
4.	Хөтөлбөрийн зорилт	<p>Зорилт 1. Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;</p> <p>Зорилт 2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;</p> <p>Зорилт 3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;</p> <p>Зорилт 4. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;</p> <p>Зорилт 5. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;</p> <p>Зорилт 6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.</p>			
5	Зардал	2018-2021 он		
		Үүнд:	Төсөв (он)	Гүйцэтгэл	Хувь
		Багц 1	1.162.577,0	1.160.000,0	99,7
6	Хөтөлбөрийн зорилт:	Биелэлт			
	1 дүгээр зорилт	Биелэлт 5 – 8 дугаар хуудас			
	2 дугаар зорилт	Биелэлт 8 - 9 дугаар хуудас			

	3 дугаар зорилт		Биелэлт 9 дүгээр хуудас						
	4 дүгээр зорилт		Хэрэгжилт болоогүй						
	5 дугаар зорилт								
	6 дугаар зорилт								
7	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		<p>Хөтөлбөрийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 71.7 хувьтай үнэлэгдсэн.</p> <p>2018 оны шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт зорилт 1-ийн хувьд 81.7, зорилт 2-ын хувьд 63.3, зорилт 3-ын хувьд 70.0 хувьтай байгаа бол зорилтын хүрээнд хэрэгжүүлэх бусад ажлууд болон бусад зорилтыг 2019 оноос хэрэгжүүлэхээр байна. Үүнд: 1 арга хэмжээ огт хэрэгжээгүй, 7 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 4 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн бол 15 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.</p> <p>Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох журам, заавар боловсруулахаар “Малын эрүүл мэнд” хөтөлбөрт тусгагдаж, биелэлтийг ханган ажилласан байна.</p> <p>Малын эрүүл мэнд хөтөлбөрийн 1 дүгээр зорилтын хүрээнд нийт 81 эрх зүйн баримт бичиг батлагдаж, 6 эрх зүйн баримт бичгийн төслийг боловсруулсан байна.</p> <p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 онд баталсан нь 2018 онд хэрэгжүүлсэн ажлыг төлөвлөгөөнд тусган, биелэлт сайн үнэлэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p> <p>2018 оны хэрэгжилтийн тайланд тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар тайлагнаагүй байна. Мөн тус хөтөлбөрийг батлуулахдаа шаардагдах санхүүгийн тооцоог хавсаргаагүй байна.</p> <p>Эдгээр бичиг баримтын нийцэлд мониторинг хийж, уялдааг хангах, сайжруулах, нэгдсэн гарын авлага хэвлүүлэх, цахим хуудаст нээлттэй байршуулах зэрэг ажлыг зохион байгуулах шаардлагатай.</p>						
8	Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дотоод, гадаадын төсөл, хөтөлбөр, олон улсын байгууллага, төрийн бус байгууллага, холбоо, аймгийн Мал эмнэлгийн газар, холбогдох эрдэм шинжилгээний байгууллага, судлаачидтай хамтран хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар ажилласан байна.						
9	Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорилтын тоо	30 ри	30 ри	30 ри	30 ри лт 4	30 ри	30 ри лт
		71.7	6	81.7	63.3	70.0	-	-	-
10	Хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ						
			... %						

"МАЛЫН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 03 дугаар сарын 28

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, мал эмнэлгийн ерөнхий газрын 2018 оны жилийн эцсийн тайлантай танилцах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох мэдээ, мэдээлэл, мөн түүнчлэн статистик мэдээ зэрэг эх сурвалжийг ашиглав.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тус хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр батлах тухай 12 дугаар тогтоолоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2019 оны “Төлөвлөгөө батлах тухай” А-11 дүгээр тушаалаар тус тус баталсан.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 6 зорилтын хүрээнд 99 арга хэмжээ төлөвлөсөн.

Хөтөлбөрийн зорилго

Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлэхэд оршино.

Хөтөлбөрийн зорилт

1. Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах;
3. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;
4. Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;
5. Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх
6. Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.

Хөтөлбөрийн хүрэх үр дүн

“Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд дараах үр дүнд хүрнэ:

- ❖ Мал эмнэлгийн салбарын нийт 22 журам, 70 зааврыг баталж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно;
- ❖ Мал, амьтны олон улсын худалдааны хорио цээрт гоц халдварт өвчингүй, тайван бүс нутгийн хэмжээг 10 хувьд хүргэнэ;
- ❖ Шинжлэх ухаанд суурилан мал, амьтныг вакцинжуулалтад хамруулах газар нутгийн хэмжээг бууруулна;
- ❖ Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар мал, амьтны халдварт өвчний гаралт, тархалтыг бууруулна;
- ❖ Мал эмнэлгийн боловсон хүчнийг чадавхжуулах замаар малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- ❖ Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллийг сайжруулна.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТОВЧ ҮР ДҮН

Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 99 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 2018 онд 3 зорилтын нийт 27 арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 1

№	Зорилт	2018 онд хэрэгжүүлэх	2019-2020 онд хэрэгжүүлэх
1	Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	18	11
2	Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах	6	13
3	Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;	3	17
4	Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;	0	9
5	Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	0	14
6	Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.	0	8
ДҮН	6	27	72

Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилт 71.7 хувьтай үнэлэгдлээ.

Хүснэгт 2.

Зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ					Хэрэгжилтийн дундаж хувь
		100	70	40	0	ХБгүй	
Зорилт 1	29	12	1	5		11	81.7
Зорилт 2	19	3	0	2	1	13	63.3
Зорилт 3	20		3			17	70.0
Зорилт 4	9					9	
Зорилт 5	14					14	
Зорилт 6	8					8	
Дүн	99	15	4	7	1	72	71.7

“Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд /Хүснэгт 2/ гүйцэтгэсэн арга хэмжээг тухайн зорилт бүрээр авч үзвэл:

Нэг. Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилтын хүрээнд: Нийт 72 заавар, 3 шаардлага, 6 журам батлагдаж, 5 журам, 1 тарифын төслийг шинэчлэн боловсруулсан байна.

Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах.

Мал, амьтны гоц халдварт шүлхий, хонь, ямааны цэцэг, шувууны томуу, боом, галзуу зэрэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх нийт 14 зааврыг шинэчлэн боловсруулж, “Мал, амьтны эрүүл мэндийн тухай” хуульд заасан хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга батлан, ХЗДХЯ-нд хүргүүлж баталгаажуулсан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах.

Мал, амьтны халдварт цусан халдвар, листериоз, дуут хавдар, адууны ям зэрэг 42 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга батлан, ХЗДХЯ-нд хүргүүлж баталгаажуулсан.

Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах.

Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг бруцеллёз, сүрьеэ зэрэг 3 нэрийн зооноз өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга батлан, ХЗДХЯ-нд хүргүүлж баталгаажуулсан.

Шимэгчтэх өвчинтэй тэмцэх стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах.

Мал, амьтанд шимэгчлэх туузан хорхой, эргүү, бэтэг зэрэг 13 нэрийн шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга батлан, ХЗДХЯ-нд хүргүүлж баталгаажуулсан. www.legalinfo.mn/annex/?lawid=13970

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл;

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 43 дугаар тогтоолоор “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам”, “Мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл”-ийг тус тус баталсан. <https://www.legalinfo.mn/annex/details/9336?lawid=14093>

Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 266 дугаар тогтоолоор “Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт”, “Хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ыг тус тус баталсан. <https://www.legalinfo.mn/law/details/13648>.

Мал амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/30 дугаар тушаалаар “Мал амьтныг нүүлгэн шилжүүлэх журам”-ыг батлаж, ХЗДХЯ-ны зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/14077>

Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар “Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар”-ыг батлаж, ХЗДХЯ-ны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан.

Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулж, бичиг баримтыг боловсруулж байна.

Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар “Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлага”-ыг батлаж, ХЗДХЯ-ны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/14090>

Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг боловсруулж батлуулах;

Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмын төслийг боловсруулсан бөгөөд төслийн хэлэлцүүлэг хийж, санал авч байна.

Түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/51 дүгээр тушаалаар “Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлага”-ыг батлаж, Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянуулан эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/14090>

Магадлан шинжилгээний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/08 дугаар тушаалаар “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журам”-ыг батлаж, ХЗДХЯ-ны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/13988>

Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/51 дүгээр тушаалаар “Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлага”-ыг батлаж, ХЗДХЯ-ны эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байршуулсан. <https://www.legalinfo.mn/law/details/14072>

Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмын төслийг шинэчлэн боловсруулж, хэлэлцүүлэг хийж байна.

Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А-178 дугаар тушаалаар баталсан ч ХЗДХЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлэх ажил удааширснаас дахин батлуулахаар ажиллаж байна.

Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;

Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулж, батлуулах;

“Мал эмнэлгийн үйлчилгээний жишиг норм, норматив тогтоох” МЭТШ2018-3Ө/01 дугаартай зөвлөх үйлчилгээний тендерээр “Монголын үндэсний мал эмнэлгүүдийн дундын хоршоо” 39,276,616 төгрөгийн өртөгтэйгээр зөвлөх үйлчилгээг гүйцэтгэсэн. Улс, орон нутгаас санхүүжүүлэх мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үйлчилгээний хөлс, вакцины хэвийн хорогдлыг судлан, тайлан ирүүлсэн байна. Уг судалгаанд үндэслэн нормативыг батлуулахаар төлөвлөөд байна.

Хоёр. Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй, тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах зорилтын хүрээнд:

Төлөвлөгөөнд 2018 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 6 ажлаас 5 ажлыг гүйцэтгэсэн байна. Үүнд:

Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийн төвийн бүсийн 7000, баруун бүсийн 7000 малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;

Шүлхийн халдвар илрүүлэх тандалтад 21 аймаг, нийслэлийн 86 сум, дүүргийг хамруулан нийт 13,555 сорьц цуглуулсан. Тандалтаар шүлхийн халдвар зүүн бүс төдийгүй төвийн бүсэд тархаад байгаа нь батлагдсан. Вакцины мониторингийн шинжилгээнд төв болон зүүн бүсийн аймгаас нийт 8100 сорьц цуглуулан шинжилгээ хийсэн.

Бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийн баруун болон зүүн бүсийн 5 аймгийн 7000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;

Бог малын мялзан өвчний халдварын тандалтыг баруун, төв, зүүн бүсийн нийт 20 аймгийн 55 сумын нийт 5280, Вакцины мониторингийн шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 25 сумын нийт 5000 сорьцод хийсэн бөгөөд дархлааны түвшин 80,7%-тай байлаа.

Үхрийн сүрьеэ өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;

Үхрийн сүрьеэ өвчнийг илрүүлэх тандалт шинжилгээг 2018 онд хэрэгжүүлээгүй байна.

Бруцеллёз өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;

Тандалтаар 17 аймаг, нийслэлийн малд хийсэн бруцеллезын шинжилгээнд нийт 242350 сорьц шинжлэгдсэнээс 0.35% буюу 856 нь эерэг /өвчтэй/ байна. Тандалтад хамруулсан сумын 46.5% (127/273), багийн 23.2% (249/1072), өрхийн 1.2% (679/54590)-д бруцеллёзын тархалттай байна. Нийт шинжлэгдсэн буурын 0.53% (11/279), бухны 0.55% (141/25453), хуцны 0.34% (396/117816), ухны 0.31% (304/97030) -д нь тус тус эерэг /өвчтэй/ байна. Аймгууд дунджаар 0.02-1.7%-ийн халдварлалттай, Булган, Дархан, Өвөрхангай аймаг, УБ хот зэрэгт бусад аймгаас халдварлалт өндөр хувьтай байна. Өмнөговь аймаг бруцеллёз өвчнөөр эрүүл, тайван байна. Шинжилгээгээр өвчтэй гарсан малыг хөнгөлөх арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлээ.

Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах арга хэмжээг зохион

байгуулах;

Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаар баталгаажуулах ажлыг 2021 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны А/61 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Төлөвлөгөөний дагуу Мал эмнэлгийн хүрээлэнтэй “Монгол улс үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлжсэн болохыг баталгаажуулах” ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх МЭЕГ2018/АГ-05 дугаартай гэрээг байгуулж, шинжилгээний ажлыг гүйцэтгэж байна.

Зарим гоц болон архаг халдварт өвчнийг сум, аймгийн түвшинд баталгаажуулан мэдээлэх;

Булган, Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Архангай, Завхан аймгийн мал эхлэн бэлтгэх үйлдвэрээс үхрийн тархины сорьц цуглуулж Үхрийн тархины эд сархиагтах өвчний шинжилгээг 2018 оны 10-р сард гүйцэтгэсэн. Лабораторийн шинжилгээний дүнгээр Монгол улсад үхрийн тархины эд сархиагтах өвчний холбогдолгүй болохыг тогтоогоод байна. Энэ нь цаашид тус улсаас гадаад орнуудад үхэр болон түүний гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход олон улсын худалдааны нэг шалгуурыг хангасан үзүүлэлт бөгөөд ДМАЭМБ-д хүсэлт илгээхээр төлөвлөж байна.

Гурав. Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгаанд үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар хяналтад авах зорилтын хүрээнд:**Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар хийх;**

Бог малын мялзан өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын чанарыг үнэлэх зорилгоор баруун бүсийн 5 аймгийн 25 сумын нийт 5000 сорьцод шинжилгээ хийсэн бөгөөд лабораторийн шинжилгээгээр дархлааны түвшин 80,7%-тайгаар үнэлэгдсэн байна.

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;

Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын чанарыг үнэлэх зорилгоор зүүн болон төвийн бүсийн 6 аймгийн 18 сумын нийт 8100 сорьц шинжилсэн бөгөөд лабораторийн шинжилгээгээр дархлааны түвшин 76,0%-тай үнэлэгдсэн байна.

Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторитой “Бруцеллэзын вакцинжуулалтын дараах мониторинг хийх ажил гүйцэтгэх” МЭЕГ2018/АГ-04 дугаартай гэрээг 33,2 сая төгрөгөөр байгуулан вакцинжуулалтын чанар, үр дүнг үнэллээ. Увс, Завхан, Дорноговь, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорнод, Сэлэнгэ аймгийн 16 сумын 960 тугал, 4160 хурга, 4160 ишиг, нийт 9228 сорьцод шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүнгээр улсын хэмжээнд вакцины дархлааны идэвх 73,4%-тай гарсан ба Завхан аймгийн Тэлмэн, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын вакцинжуулалтын дүн хангалтгүй байна.

2018 онд шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийн үнэлгээ

Хүснэгт 3

№	Шалгуур үзүүлэлт	Үнэлгээ
1	Мал эмнэлгийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох	
	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Малаас хүнд дамжин халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Шимэгчтэх өвчинтэй тэмцэх стандарт ажиллагааны зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр, тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналтад авах журам болон мах бэлтгэл, отор, нүүдлийн зорилгоор аймаг дамжиж мал туух тууврын замын чиглэл;	100

	Хорио цээрийн дэглэм тогтоох өвчний жагсаалт, дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Мал амьтныг нүүлгэн шилжүүлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Мал бэлтгэх, тууварлах, тээвэрлэх, үйлдвэрт хүлээн авах үеийн мал эмнэлэг хорио цээрийн журам, мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ хийх, баталгааны тэмдэг хэрэглэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	40
	Мал, эмнэлэг, ариун цэврийн шаардлагыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Жороор олгох мал, амьтны эмийн жагсаалт, журмыг боловсруулж батлуулах;	40
	Түүхий эд, бүтээгдэхүүний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Магадлан шинжилгээний мал эмнэлгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Үйлдвэр, цехэд түүхий сүү нийлүүлэх, худалдах үед мөрдөх ариун цэвэр, эрүүл ахуйн зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	100
	Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	40
	Төгсөлтийн дараахь үргэлжилсэн сургалт явуулах болон малын эмчид итгэмжлэл олгох, түдгэлзүүлэх, цуцлах журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	70
	Малын эмч, мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн боловсруулж, батлуулах;	40
	Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх мал эмнэлгийн үйлчилгээний зардлын нормативыг шинээр боловсруулж, батлуулах;	40
	Дундаж	81.7
	Мал, амьтны гоц халдварт болон халдварт, шинэ болон дахин сэргэж байгаа өвчнийг эрт илрүүлэх тандалтыг өргөжүүлэх замаар өвчнийг хяналтад авч, халдварт өвчингүй тайван байдлыг лабораторийн шинжилгээний үр дүнг харгалзан бүс нутгаар баталгаажуулах	
	Шүлхий өвчийг эрт илрүүлэх тандалт шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг төвийн бүсийн 7000, баруун бүсийн 7000 малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	100
	Бог малын мялзан өвчнийг эрт илрүүлэх шинжилгээ, вакцинжуулалтын дараахь мониторингийг баруун болон зүүн бүсийн 5 аймгийн 7000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	100
2	Үхрийн сүрьеэ өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	0
	Бруцеллёз өвчнийг тандах шинжилгээг баруун бүсийн 5 аймгийн 10000 мянган малыг жил бүр шинжлэх арга хэмжээг зохион байгуулах;	100
	Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах арга хэмжээг зохион байгуулах;	40
	Зарим гоц болон архаг халдварт өвчнийг сум, аймгийн түвшинд баталгаажуулан мэдээлэх;	40
	Дундаж	63.3
	Мал, амьтны гоц халдварт, зооноз, шинэ болон дахин сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг шинжлэх ухааны нотолгоо, тархвар зүйн судалгааг үндэслэн төлөвлөх замаар бүс нутгаар нь хяналтад авах;	
3	Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар хийх;	70.0

	Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	70.0
	Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын чанар, үр дүнг тархвар зүйд суурилсан тандалт (лабораторийн шинжилгээ)-ын аргаар зохион байгуулах;	70.0
	Дундаж	70.0
4	Мал, амьтны шилжилт хөдөлгөөний хяналтыг сайжруулах замаар гоц халдварт өвчин гарах, тархах шалтгаан, нөхцөлийг таслан зогсоох;	-
	Дундаж	ХБгүй
5	Мал эмнэлгийн байгууллагын мэргэжилтэн, малын эмч нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	-
	Дундаж	ХБгүй
6	Малчин, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийг мал, амьтны эрүүл мэнд, түүнтэй шууд холбогдох нийтийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, мэдээллээр хангаж, үр дүнг сурталчлан таниулах.	-
	Дундаж	ХБгүй
Ерөнхий дундаж үнэлгээ		71.7

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

1. “Малын эрүүл мэнд” хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн 2018 оны хэрэгжилтийн ерөнхий дундаж үнэлгээ 71.7 хувьтай үнэлэгдсэн ба 2018 оны төлөвлөгөөнөөс 1 арга хэмжээ огт хэрэгжээгүй, 7 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай, 4 арга хэмжээ тодорхой үр дүнд хүрсэн бол 15 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2019 онд баталсан нь 2018 онд хэрэгжүүлсэн ажлыг төлөвлөгөөнд тусган, биелэлт сайн үнэлэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
3. 2018 оны хэрэгжилтийн тайланд тус хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний санхүүгийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаар тайлагнаагүй байна. Мөн тус хөтөлбөрийг батлуулахдаа шаардагдах санхүүгийн тооцоог хавсаргаагүй байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

1. “Малын эрүүл мэнд” үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний нэгдсэн төсвийг батлуулах (МЭЕГ), салбарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан арга хэмжээг бүрэн тусгах (ХХААХҮЯ-ны ТЗУГ), арга хэмжээний үр дүн, үр нөлөөллийг дүгнэхэд боломжтой байдлаар тайланг бэлтгэхэд анхаарах (МЭЕГ),
2. Тайлагнаж байгаа болон тайланг нэгтгэж байгаа мэргэжилтнүүд хяналт-шинжилгээ, үнэлгээтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг судлах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлага хангасан тайлан ирүүлэх (МЭЕГ),
3. Шинээр баталсан эрх зүйн баримт бичгүүдийн уялдаа, хийдэлд мониторинг хийж, сайжруулах арга хэмжээг тодорхой давтамжтайгаар зохион байгуулах (МЭЕГ), салбарын эрх зүйн баримт бичгийн гарын авлага хэвлүүлэх (МЭЕГ), цахим хуудаст эрх зүйн баримт бичгийг нээлттэй байршуулах (МЭЕГ), шинэчлэн баталсан эрхзүйн баримт бичиг (журам, заавар)-ийн өмнөх хувилбарыг хүчингүй болгох (БТГ, ХХ, МЭЕГ),
4. Шинээр батлагдсан эрх зүйн баримт хэрэгжилт хангах, 2019 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх (МЭЕГ) зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг зөвлөмж болгож байна.